

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦЭЦЭГ СУМЫН ЕБС-ИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/57/СТА-ТШЗ

| | |
|---|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p> | <p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас: 70432545 цахим хаяг: Munkhtulga.d@audit.gov.mn</p> |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-----------------|--|
| АДБОУС | <i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i> |
| АОУС | <i>Аудитын Олон Улсын Стандарт</i> |
| УСНББОУС | <i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i> |
| ТТЗ | <i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i> |
| ТШЗ | <i>Төсвийн шууд захирагч</i> |
| ЕБС | <i>Ерөнхий боловсролын сургууль</i> |
| НДШ | <i>Нийгмийн даатгалын шимтгэл</i> |
| ХАОАТ | <i>Хүн амын орлогын албан татвар</i> |
| ЗДТГ | <i>Засаг даргын тамгын газар</i> |
| СТСХ | <i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i> |
| БШУЯ | <i>Боловсрол шинжлэх ухааны яам</i> |

Агуулга

| | |
|---|----|
| 1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 10 |
| 3. Аудитын тайлан..... | 10 |
| 3.1. Ерөнхий зүйл..... | 10 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй..... | 11 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт | 11 |
| 3.4. Материаллаг байдал | 12 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 12 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт | 13 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл..... | 14 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 3.9. Аудитын илрүүлэлт..... | 15 |
| Залруулсан алдаа..... | 15 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил | |
| Аудитын зөвлөмж..... | 15 |
| 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд | 15 |
| 4. Менежментийн захидал | 15 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 16 |

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагэвэр бөг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 4/49
таныг _____ -ны № _____ -Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ЦЭЦЭГ СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.МӨНХТӨР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэг сумын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэг сумын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанар зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>66,013,993.12</u> | <u>91,671,874.32</u> |
| 33 | АВЛАГА | 9,434,132.00 | 6,651,625.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 8,534,132.00 | 5,336,500.00 |
| 335 | Бусад авлага | 900,000.00 | 1,315,125.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 415,125.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 900,000.00 | 900,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 56,579,861.12 | 85,020,249.32 |
| 351 | Түүхий эд материал | 3,926,085.00 | 5,634,745.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,926,085.00 | 3,926,085.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 1,708,660.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 16,183,535.12 | 24,075,563.32 |
| 354 | Хангамжийн материал | 20,703,241.00 | 31,294,941.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,105,800.00 | 2,161,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 712,000.00 | 390,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 750,500.00 | 290,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,502,800.00 | 14,820,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,632,141.00 | 13,632,141.00 |
| 35600 | Мал амьтад | 15,767,000.00 | 24,015,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,420,521,879.86</u> | <u>1,811,384,957.92</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,420,521,879.86 | 1,811,384,957.92 |
| 392 | Биет хөрөнгө | 1,372,873,879.86 | 1,763,736,957.92 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,362,811,784.00 | 1,834,811,784.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -81,850,530.80 | -200,185,190.04 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 29,736,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -21,063,306.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 126,701,299.00 | 168,780,769.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -109,694,613.50 | -125,760,269.20 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 103,390,497.00 | 114,061,497.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -63,744,634.40 | -71,904,839.10 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 100,000.00 | 100,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -100,000.00 | -100,000.00 |
| 39217 | Ном | 35,260,078.56 | 35,260,078.56 |
| 393 | Биет бус хөрөнгө | 47,648,000.00 | 47,648,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 47,648,000.00 | 47,648,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,486,535,872.98</u> | <u>1,903,056,832.24</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>1,548,610.00</u> | <u>1,737,997.08</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,548,610.00 | 1,737,997.08 |
| 413 | Өглөг | 1,548,610.00 | 1,737,997.08 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 200,000.00 | 29,997.08 |
| 4136 | Бусад өглөг | 1,348,610.00 | 1,708,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,348,610.00 | 1,708,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,484,987,262.98</u> | <u>1,901,318,835.16</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,484,987,262.98 | 1,901,318,835.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 675,655,846.74 | 675,655,846.74 |
| 51101 | Өмч: - төрийн | 675,655,846.74 | 675,655,846.74 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -122,724,621.27 | 293,606,950.91 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -122,724,621.27 | -134,394,603.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 428,001,554.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 932,056,037.51 | 932,056,037.51 |

| | | | |
|---|---|------------------|------------------|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,486,535,872.98 | 1,903,056,832.24 |
|---|---|------------------|------------------|

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,189,092,937.00 | 1,565,734,634.40 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 313,993,552.00 | 572,108,334.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 311,993,552.00 | 572,108,334.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 311,993,552.00 | 572,108,334.40 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 393,600.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 311,393,552.00 | 571,714,734.40 |
| 120005 | Түрээсийн орлого | 00.00 | |
| 122 | Тусламжийн орлого | 2,000,000.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 2,000,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 875,099,385.00 | 993,626,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 739,092,700.00 | 861,340,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 00.00 |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 00.00 | 00.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 00.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 739,092,700.00 | 861,340,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,530,285.00 | 1,604,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,530,285.00 | 1,604,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 133,476,400.00 | 130,682,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 133,476,400.00 | 130,682,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 961,034,421.15 | 1,137,733,080.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 961,034,421.15 | 1,137,733,080.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 932,932,921.15 | 1,111,505,900.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 591,742,818.00 | 708,791,905.49 |
| 210101 | Үндсэн цалин | 539,524,803.00 | 650,549,792.49 |
| 210104 | Урамшуулал | 52,218,015.00 | 58,242,113.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 75,189,771.00 | 89,563,863.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,189,771.00 | 89,563,863.59 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 132,092,500.00 | 129,185,310.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,569,200.00 | 7,151,810.00 |
| 210302 | Түлш, халаалт | 124,904,600.00 | 121,433,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 618,700.00 | 600,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,960,241.72 | 4,834,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 856,000.00 | 599,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,406,335.00 | 2,743,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 589,600.00 | 572,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 214,400.00 | 209,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 205,300.00 | 205,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,688,606.72 | 425,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 80,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 29,962,400.00 | 18,831,315.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 267,000.00 | 3,477,215.00 |
| 210502 | Хоол, хүнс | 28,304,500.00 | 14,060,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,390,900.00 | 1,293,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,525,200.00 | 1,072,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,525,200.00 | 1,072,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,116,400.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,116,400.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 274,300.00 | 553,200.00 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 76,900.00 | 164,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 197,400.00 | 389,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 84,069,290.43 | 158,603,505.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 455,200.00 | 16,113,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,768,000.00 | 3,835,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,846,090.43 | 138,324,645.98 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 330,760.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 28,101,500.00 | 26,227,180.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 27,938,000.00 | 16,677,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,248,000.00 | 16,677,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,690,000.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 163,500.00 | 9,549,580.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 163,500.00 | 9,549,580.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 228,058,515.85 | 428,001,554.34 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 228,058,515.85 | 428,001,554.34 |

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 877,699,385.00 | 994,019,900.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,600,000.00 | 393,600.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 600,000.00 | 393,600.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 600,000.00 | 393,600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 393,600.00 |
| 122 | Тусламжийн орлого | 2,000,000.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 2,000,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 875,099,385.00 | 993,626,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 739,092,700.00 | 861,340,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 739,092,700.00 | 861,340,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,530,285.00 | 1,604,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,530,285.00 | 1,604,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 133,476,400.00 | 130,682,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 133,476,400.00 | 130,682,100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 877,699,385.00 | 994,019,900.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 877,699,385.00 | 994,019,900.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 848,297,885.00 | 967,792,720.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 598,773,500.00 | 701,006,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 419,996,355.00 | 462,082,200.00 |
| 210102 | Нэмэгдэл | 138,046,000.00 | 190,022,112.77 |
| 210104 | Урамшуулал | 40,731,145.00 | 48,902,187.23 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 74,846,500.00 | 94,635,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,895,600.00 | 66,595,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,987,700.00 | 7,010,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,790,200.00 | 5,608,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,197,500.00 | 1,402,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,975,500.00 | 14,020,100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 132,543,700.00 | 129,232,110.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,585,700.00 | 7,074,110.00 |
| 210302 | Түлш, халаалт | 124,558,000.00 | 121,258,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 900,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,773,385.00 | 4,885,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 426,500.00 | 426,500.00 |

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,267,085.00 | 2,396,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 589,600.00 | 572,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 379,100.00 | 379,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 205,300.00 | 205,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 905,800.00 | 905,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 29,887,100.00 | 30,722,560.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 242,000.00 | 5,591,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 28,544,300.00 | 23,430,760.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,100,800.00 | 1,700,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 881,700.00 | 766,450.00 |
| 210604 | Урсгал засвар | 881,700.00 | 766,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,116,400.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,116,400.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 197,400.00 | 392,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 197,400.00 | 392,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,278,200.00 | 6,081,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 884,500.00 | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,393,700.00 | 5,481,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29,401,500.00 | 26,227,180.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 29,238,000.00 | 16,677,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,548,000.00 | 16,677,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,690,000.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 163,500.00 | 9,549,580.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 163,500.00 | 9,549,580.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 00.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|------------------------|--|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 633,755,846.74 | 502,170,505.00 | -307,404,083.91 | 828,522,267.83 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 833,177.48 | 833,177.48 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 633,755,846.74 | 502,170,505.00 | -306,570,906.43 | 829,355,445.31 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -24,406,774.06 | -24,406,774.06 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 675,655,846.74 | 932,056,037.51 | -122,724,621.27 | 1,484,987,262.98 |
| D01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 675,655,846.74 | 932,056,037.51 | -122,724,621.27 | 1,484,987,262.98 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -11,669,982.16 | -11,669,982.16 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 675,655,846.74 | 932,056,037.51 | -134,394,603.43 | 1,473,317,280.82 |

| | | | | | |
|-----|--|-----------------------|-----------------------|-----------------------|------------------|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 428,001,554.34 | 428,001,554.34 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 675,655,846.74 | 932,056,037.51 | 293,606,950.91 | 1,901,318,835.16 |

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 993,391,300.00 | 982,866,120.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 993,391,300.00 | 982,866,120.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 972,111,800.00 | 966,188,520.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 701,006,500.00 | 701,006,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 462,182,200.00 | 462,082,200.00 |
| 210102 | Нэмэгдэл | 190,295,200.00 | 190,022,112.77 |
| 210104 | Урамшуулал | 48,529,100.00 | 48,902,187.23 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 94,635,900.00 | 94,635,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,595,600.00 | 66,595,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,010,100.00 | 7,010,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,608,100.00 | 5,608,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,402,000.00 | 1,402,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,020,100.00 | 14,020,100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 130,682,100.00 | 129,232,110.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,524,100.00 | 7,074,110.00 |
| 210302 | Түлш, халаалт | 121,258,000.00 | 121,258,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 900,000.00 | 900,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,885,300.00 | 4,885,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 426,500.00 | 426,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,396,000.00 | 2,396,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 572,600.00 | 572,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 379,100.00 | 379,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 205,300.00 | 205,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 905,800.00 | 905,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,986,700.00 | 30,722,560.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,591,000.00 | 5,591,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,694,900.00 | 23,430,760.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,700,800.00 | 1,700,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 769,200.00 | 766,450.00 |
| 210604 | Урсгал засвар | 769,200.00 | 766,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 276,400.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 276,400.00 | 70,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 392,000.00 | 392,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000.00 | 392,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4477700.00 | 4477700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,000.00 | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,877,700.00 | 3,877,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 21279500.00 | 16677600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,279,500.00 | 16,677,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,279,500.00 | 16,677,600.00 |

| | | | |
|---------------|--|----------------|----------------|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 993,391,300.00 | 982,866,120.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 861,340,000.00 | 852,473,960.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 861,340,000.00 | 852,473,960.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 131,451,300.00 | 129,998,560.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 131,451,300.00 | 129,998,560.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 600,000.00 | 393,600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 393,600.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 00.00 | 00.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 55 | 55 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 36 | 36 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18 | 18 |

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|-------------|--|-------------------|---------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4530285.00 | 1,602,400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4530285.00 | 1,602,400.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1840285.00 | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 150285.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 150285.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 850000.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 850000.00 | 00.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 840000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 840000.00 | 00.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2690000.00 | 1602400.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2690000.00 | 1,602,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2690000.00 | 00.00 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,602,400.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4530285.00 | 1602400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4530285.00 | 1,602,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2000000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2530285.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,602,400.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Цэцэг сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Д.Мөнхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын анхан шатны баримт бүрдүүлэлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага
- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлнэ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цэцэг сумын ЕБС-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСУГ-ын дотоод хяналтыг 2020 онд тус байгууллагад хэрэгжүүлээгүй мөн дотоод аудитын алба тус байгууллагад ямар нэгэн хяналт, шалгалт хийгээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Цэцэг сумын ЕБС-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны 3-р улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 561182.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5611.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1568237.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 15682.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Цэцэг сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 416520.96 мянган төгрөгөөр буюу 28 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
|--|---------------------|---------------------|-------------------|------------|
| Авлага | 9,434.13 | 6,651.62 | -2,782.51 | -29% |
| Бараа материал | 56,579.86 | 85,020.25 | 28,440.39 | 50% |
| Үндсэн хөрөнгө | 1,420,521.88 | 1,811,384.96 | 390,863.08 | 28% |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,486,535.87 | 1,903,056.83 | 416,520.96 | 28% |
| Богино хугацаат өр төлбөр | 1548.61 | 1,738.00 | 189.39 | 12% |
| Цэвэр хөрөнгө, өмч | 1,484,987.26 | 1,901,318.83 | 416,331.57 | 28% |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,486,535.87 | 1,903,056.83 | 416,520.96 | 28% |

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 6651.62 мянган төгрөг болж 2782.51 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд өмнөх онд цалингийн урьдчилгааны авлагаас 633.2 мянган төгрөг, НДШ-ийн авлагыг 766.7 мянган төгрөг, цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын авлагыг 1372.8 мянган төгрөг, хувь хүмүүстэй холбоотой 994.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулан ажиллаж эргэлтийн эмийн сангаас авах авлагыг 415.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 85020.85 мянган төгрөг болж 28440.39 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 41762.2, БСУГ-аас 6842.0, малын нас дэвшилтээр 24015.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж 28101.2 мянган төгрөгийн бараа материалын үйл ажиллагаандаа зарцуулж малын нас дэвшүүлж эхний үлдэгдлийг 15767.0 мянган төгрөгийн акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1420521.88 мянган төгрөг, оны эцэст 1811384.96 мянган төгрөг болж 390860.08 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 472000.0 мянган төгрөгийн их засвар, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 52750.47 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, Цэцэг сумын Эрүүл мэндийн төвөөс 29079.47 мянган төгрөгийн тээврийн хэрэгслээр нэмэгдэж нийт 554486.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэлд тусгаж, шилжиж ирсэн тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл 13629.2 мянган төгрөг, барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдлийн зөрүү 11669.98 мянган төгрөг, тайлант оны элэгдлийн зардал 138324.6 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1738.0 мянган төгрөг болж 189.39 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд үүссэн 1548.6 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулан ажиллаж тайлант онд ҮЭ-ийн өглөг 30.0 мянган төгрөг, аж ахуйн нэгжтэй холбоотой 171708.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 1901318.83 мянган төгрөг болж 416331.57 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үр дүн дансанд хуримтлагдсан элэгдлийн зөрүү 11669.98 мянган төгрөгийн залруулж тайлант үеийн үр дүн 428001.55 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Цэцэг сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 376641.7 мянган төгрөгөөр буюу 31.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 376641.7 мянган төгрөгийн орлогоос тусгай зориулалтын санхүүжилтийн орлого 122247.3, үнэ төлбөргүй орлого 260321.2, түрээсийн орлого 1604.2 мянган төгрөгөөр өсөж туслах үйл ажиллагааны орлого 206.4, хандав тусламжийн орлого 2000.0, нэмэлт санхүүжилтийн орлого 2530.3, орон нутгаас авах санхүүжилтийн орлого 2794.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 176698.6 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 176698.6 мянган төгрөгийн зардал нь цалин шимтгэлийн зардал 131423.2 мянган төгрөг буюу 19.7 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 278.9 мянган төгрөг буюу 101.7 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 74534.2 мянган төгрөг буюу 88.6 хувиар тус тус өсөж тогтмол зардал 2907.2 мянган төгрөг буюу 2.2 хувиар, хангамж бараа материалын зардал 8125.4 мянган төгрөг буюу 62.7 хувиар, нормативд зардал 11131.1 мянган төгрөг буюу 37.1 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 4453.2 мянган төгрөг буюу 80.6 хувиар, томилолтын зардал 1046.4 мянган төгрөг буюу 93.7 хувиар, урсгал шилжүүлэг 1874.3 мянган төгрөг буюу 6.6 хувиар тус тус буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр хуримтлагдсан элэгдлийн зөрүүтэй холбоотой 11669.98 мянган төгрөгийн бичилт хийгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 993391.3 мянган төгрөгөөр нийт зарлагыг 993391.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 861340.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 131451.3 мянган төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлогыг 600.0 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 993391.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 993391.3 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 861340.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 131451.3 мянган төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлогыг 600.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 993391.3 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 861340.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 130682.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 393.6 санхүүжилт авч орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 769.2 мянган төгрөгөөр дутуу авч, туслах үйл ажиллагааны орлогыг 206.4 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлж 982866.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 9549.6 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 982866.1 мянган төгрөг буюу 98.9% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|----------|-----------------------|------------|
| 81806 | Дотуур байр | 4264.2 |
| 81801 | Үдийн цай | 4601.9 |
| 80109 | Тогтмол зардал | 683,5 |
| Нийт дүн | | 9549.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар номын түрээсээр 1604.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 1604.2 мянган төгрөгийн номын орлогыг БШУЯ-нд шилжүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 73, хугацаа хоцроож байршуулсан 1, мэдээллийг огт оруулаагүй 1, мэдээлэл дутуу оруулсан 4 мэдээлэл байна. 10, 11, 12 дугаар сарын үдийн цайны зардлыг мэдээлээгүй, 3 сарын халаалтын зардал мэдээлээгүй байна. Санхүүгийн тайлан дараа жилийн төсвийн төслийн PDF цайл алдаатай мэдээлэгдсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цэцэг ЕБС нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах албан шаардлага, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|---------|---------|--------|-------|------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 4 | 13876.1 | 2 | 4067.1 | 2 | 9809 | 33.3 |

| | | | | | | | |
|----------|---|---------|---|--------|---|------|------|
| Нийт дүн | 4 | 13876.1 | 2 | 4067.1 | 2 | 9809 | 33.3 |
|----------|---|---------|---|--------|---|------|------|

Өмнөх оны санхүүгийн тайлангаар өгөгдсөн 4 зөвлөмжийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Цалингийн урьдчилгааны авлагыг бүрэн барагдуулан ажиллах зөвлөмж, хүүхдийн хүнсний материалаас бусад үйл ажиллагаанд зарцуулахгүй байх зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24467.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс 16675.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж 7792.0 мянган төгрөгийн алдаанд албан шаардлага бичиж 2 зөвлөмж бичигдлээ.

Залруулсан алдаа: Аудитаар 16675.8 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Үүнд:

- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг 11669.98 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг өмнөх үеийн үр дүн дансанд залрууллаа.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 5005.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг мөнгөн гүйлгээний тайлан болон үр дүнгийн тайланд залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 7792.0 мянган төгрөгийн 2 алдаанд албан шаардлага бичигдлээ.

Үүнд:

- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн цалингийн урьдчилгааг бүрэн суутган аваагүй холбоотой 5320.0 мянган төгрөгийн урьдчилгааг бүрэн суутган авах албан шаардлага бичигдлээ.
- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн дотуур байрны хүүхдийн хоолны материалыг бусад үйл ажиллагаанд зарцуулахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлэхгүйгээр тайлант онд 2472.0 мянган төгрөгийн хүнсний материалыг зарцуулсанд албан шаардлага бичигдлээ.

Аудитын зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар цалингийн нэмэгдэл олгосон тушаал шийдвэрийн хэрэгжилтийн талаарх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлт

1.1 **Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, захилгаар хийгдсэн судалгааны ажлуудад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна

1.2 Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

2.1 Илрүүлэлт: Шилэн дансны сайтад байршуулах мэдээллээс 71 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг бүрэн байршуулаагүй, 10, 11, 12 дугаар сарын үдийн цайны зардлыг мэдээлээгүй, 3 сарын халаалтын зардлыг мэдээлээгүй байна.

2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, иргэд мэдээллээр ил тод хангагдах байдал алдагдах, шилэн дансны тухай хууль зөрчигдөх

2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заавал байршуулна гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|------------------------------|----------------------|--|---------------------|
| Огноо: | Аудитын нэр: | Цэцэг сумын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
| 2021 | | | ХОА-2021/57/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Цэцэг сумын сургууль | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---------------------------|------------|---------------------------------------|---|----------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |

| | | | | | |
|------------|--|---------|-----------------|-------------------------|-------------------------|
| 1 | Цалингийн урьдчилгааны авлагыг бүрэн суутган аваагүй | 5320.0 | Албан шаардлага | Захирал, нягтлан бодогч | Д.Мөнхтөр Г.Гантулга |
| 2 | Дотуур байрны хүүхдийн хүнсний материалыг бусад үйл ажиллагаанд зарцуулсан. | 2472.0 | Албан шаардлага | | |
| 3 | Т Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, захилгаар хийгдсэн судалгааны ажлуудад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна. | 0 | Зөвлөмж өгөх | | |
| 4 | Шилэн дансны сайтад байршуулах мэдээллийг 71 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээллийг мэдээлээгүй | 0 | Зөвлөмж өгөх | | |
| 5 | Санхүүгийн тайланд залруулга хийх | 16675.8 | Залруулга хийх | | |
| ДҮН | | 24467.8 | | | |

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР